





<p>Батлав.</p> <p></p> <p>ТУЗ-ийн дарга Л.Ариунболд</p>	<p>Боловсруулсан:</p> <p>ТУЗ-ийн нарийн бичгийн дарга <u>О.Билгүүн</u> О.Билгүүн</p> <p>Хянасан:</p> <p>ТУЗ-ийн хараат бус гишүүн <u>Ч.Зоригтбаатар</u> Ч.Зоригтбаатар</p> <p>Батласан тогтоол: <u>2023.07.28</u></p>	
<p>Баримт бичгийн код: MBW-BOD-05</p>	<p>Хувилбар № 01</p>	<p>Шинэчилсэн:</p>


БИЗНЕСИЙН ЁС ЗҮЙН ДҮРЭМ

<p>Баримт бичгийн төлөв:</p> <p><input checked="" type="checkbox"/> Эх хувилбар</p> <p><input type="checkbox"/> Хуулбар</p> <p><input type="checkbox"/> Хучингүй</p>	<p>Дардас</p>
--	---------------

	Бизнесийн ёс зүйн дүрэм	Хувилбар:01
	Дугаар: MBW-BOD-05	Шинэчилсэн:

АГУУЛГА

1. Нийтлэг үндэслэл
2. Хүний эрхийг дээдлэх ёс зүй
3. Шударга бизнесийн ёс зүйн дүрэм
 - a. Өрсөлдөөний ёс зүй
 - b. Авилгын эсрэг ёс зүй
 - c. Бэлэг, хандивын ёс зүй
 - d. Мөнгө угаахтай тэмцэх ёс зүй
 - e. Ашиг сонирхлын зөрчлийн ёс зүй
 - f. Нийлүүлэгчийн ёс зүй
4. Хөрөнгө хамгаалах ёс зүйн дүрэм
 - a. Компанийн хөрөнгө ашиглах ёс зүй
 - b. Залилангийн эсрэг ёс зүй
 - c. Мэдээллийн нууц хамгаалах ёс зүй
 - d. Оюуны өмчийг хамгаалах ёс зүй
 - e. Олон нийтийн сүлжээ ашиглах ёс зүй
5. Шүгэл үлээх
 - a. Таны үүрэг
 - b. Мэдээлэл хүлээн авах
 - c. Хариу арга хэмжээ
 - d. Сахилгын болон хуулийн хариуцлага

	Бизнесийн ёс зүйн дүрэм	Хувилбар:01
	Дугаар: MBW-BOD-05	Шинэчилсэн:

БИЗНЕСИЙН ЁС ЗҮЙН ДҮРЭМ

Нэг. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

“Монгол базальт” ХК-ийн Бизнесийн ёс зүйн дүрмийн зорилго нь компанийн эрх бүхий албан тушаалтан, нийт ажилтнуудын өдөр тутмын бизнесийн үйл ажиллагаандаа баримтлах ёс зүйн хэм хэмжээг тодорхойлоход оршино.

Бизнесийн ёс зүйн дүрмийг зөвхөн ажлын байранд байхдаа мөрдөх биш өөрийн ажил үүргийг гүйцэтгэх, компанийг төлөөлөх бүхий л цаг хугацаанд аливаа үйлдэл хийхэд анхаарах зүйлсийн үндсэн зарчмуудыг тусгасан болно.

Бизнесийн ёс зүйн дүрмийг дараах этгээдүүд заавал дагаж мөрдөх үүрэгтэй бөгөөд өөрийн үйл ажиллагаандаа Монгол базальт ХК-ийн болон хамт олны нэр хүндийг үргэлж хүндэтгэж, ёс зүйтэй байхыг шаардана. Үүнд:

- Компанийн эрх бүхий албан тушаалтан
- Нийт ажилтнууд
- Гэрээт ажилтан, хамтын ажиллагаа бүхий борлуулагч нар
- Ханган нийлүүлэгчид

Энэхүү дүрэмд хэрэглэсэн нэр томъёог дор дурьдсан утгаар ойлгоно.

“компанийн ашиг сонирхол” гэж компанийн бодлогын баримт бичиг, хөтөлбөр, дүрэм журам, шийдвэрт нийцсэн эдийн болон эдийн бус ашиг сонирхолыг

“хувийн ашиг сонирхол” гэж ажил үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон хамаарал бүхий этгээдийн зүгээс нөлөөлж болохуйц эдийн болон эдийн бус ашиг сонирхолыг

“давуу байдал” гэж нэр төр, албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашигласнаар хувь хүн, хуулийн этгээдэд бий болох эдийн болон эдийн бус ашигтай байдлыг

“эрх бүхий албан тушаалтан” гэж төлөөлөн удирдах зөвлөл /цаашид ТУЗ гэх/-ийн дарга, гишүүн, нарийн бичгийн дарга, гүйцэтгэх захирал, гүйцэтгэх захирлын багийн гишүүн, ерөнхий нягтлан бодогч нарыг


“шүгэл үлээх” гэж компанийн болон ажилтнуудын эрх ашиг сонирхол хохирсон, хохироож болзошгүй нөхцөл байдал, үйлдэл эс үйлдэхүйн талаар эрх бүхий этгээдэд мэдээлэл өгөх, өргөдөл гомдол гаргах, тайлбар өгөхийг

“шүгэл үлээгч” гэж шүгэл үлээх үйлдэлийг хийсэн хүн, хуулийн этгээдийг

Хоёр. ХҮНИЙ ЭРХИЙГ ДЭЭДЛЭХ ЁС ЗҮЙ

Компанийн эрх бүхий албан тушаалтан болон ажилтнууд хүний эрхэм чанар, хүний үндсэн эрхийг дээдэлж бизнес эрхлэх ба ёс зүйн дараах зарчмыг баримтална. Үүнд:

- ХҮНИЙ ЭРҮҮЛ МЭНД БОЛОН АЮУЛГҮЙ БАЙДАЛ

	Бизнесийн ёс зүйн дүрэм	Хувилбар:01
	Дугаар: MBW-BOD-05	Шинэчилсэн:

Компани аюулгүй, эрүүл ажиллах орчныг бүрдүүлэх үүрэгтэй ба ажилтан нэг бүрийг хамгаалах хувцас, багаж хэрэгсэл, сургалтаар хангаж хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн бодлого, дүрэм журмыг тогтоон мөрдүүлдэг.

Ажилтан бүр өөрийн болон бусдын аюулгүй байдалд анхаарч хөдөлмөрлөх ба аливаа эрсдэл бүхий нөхцөл байдал үүссэн даруй ажлыг зогсоож хүний эрүүл мэнд, аюулгүй байдлыг үргэлж НЭГТ тавьж ажиллана.

- ҮЛ ЯЛГАВАРЛАХ

Арьс өнгө, хүйс, бэлгийн чиг баримжаа, шашин шүтлэг, яс үндэс, нийгмийн гарал, нас, хөгжлийн бэрхшээл болон бусад зүйлсээр хүнийг үл ялгаварлах зарчимд үндэслэн бүх хүмүүстэй тэгш, шударга харьцана. Ажилтнуудыг тэгш боломжийн зарчмаар ажилд авч, урамшуулж, албан тушаал дэвшүүлэх, томилох ба ажилтны мэргэжлийн ур чадвар, мэргэшил, туршлага, хөгжлийг харгалзан шийдвэр гаргах ёс зүйг баримтална.

- ДАРАМТ ҮЗҮҮЛЭХГҮЙ, ХҮЧИРХИЙЛЭХГҮЙ БАЙХ

Ажилтан бүрийн хүний эрхэм чанар, тэгш байдлыг хангах үндэс нь ямар ч төрлийн дарамт, хүчирхийлэл гаргахгүй байх, гарсан тохиолдолыг мэдээлэх, тохирсон хариу арга хэмжээ авах үүрэг юм. Хэн ч хэнд ч бие махбодийн, үгийн, бэлгийн болон сэтгэл зүйн дарамт, дээрэлхэлт, хүчирхийлэл, заналхийлэл үзүүлэхийг тэвчиж үл болох ёс зүйг баримтална. Энэ нөхцөл байдлыг ажлын байранд болон компанийн нэрийн өмнөөс ажиллаж буй хэнд ч зөвшөөрөхгүй.

- ХҮҮХДИЙН ЭРХИЙН ХАМГААЛАЛТ

Нэгдсэн үндэсний байгууллагын Хүүхдийн эрхийн конвенцид зааснаар хүүхдийн сурч боловсрох, амрах, тоглох болон бүхий л хэрэгцээгээ хангуулах эрхийг хүндлэн дээдлэх ба компанийн үйлдвэр, ажлын байр, ханган нийлүүлэгчийн ажлын байранд насанд хүрээгүй хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжихгүй, зөвшөөрөхгүй байх ёс зүйг баримтална.

Компани 18 наснаас дээш насны хүнийг ажиллуулна.

- ЭВЛЭЛДЭН НЭГДЭХ ЭРХ


Ажилтнуудаа хариуцлага тооцох айдасгүйгээр хуулийн дагуу Үйлдвэрчний эвлэлээр өөрсдийгөө төлөөлүүлэх эрхийг хүндлэх ба ажилтны төлөөллийн саналыг хууль тогтоомжийг зөрчихгүйгээр ач холбогдолтой харилцах бүхий л боломжоор хүлээн авах ёс зүйг баримтална.

- АЛБАДАН ХӨДӨЛМӨРЛҮҮЛЭХГҮЙ БАЙХ

Хэнийг ч хүчирхийлэх, айлган сүрдүүлэх, баримт бичиг, хөрөнгийг барьцаалах аргаар албадан ажиллуулах нөхцлийг үл тэвчих ёс зүйг баримтална. Бүх ажилтнууд чөлөөтэй ажиллах, өөрийн хөдөлмөр эрхлэлтийн нөхцлийг сайтар мэдэж, тохиролцсоны дагуу ажиллаж, хөдөлмөрийн хөлсийг хууль тогтоомж, дүрэм журмын дагуу тооцуулж авна.

- АМРАЛТ, ЧӨЛӨӨТ ЦАГ БОЛОН ШУДАРГА ЦАЛИН

Хүнийг амрах болон чөлөөт цагтай байх эрхийг анхаарах бөгөөд ажлын цаг, илүү цаг, шөнийн цаг, ээлжийн амралт зэргийг Монгол улсын хууль тогтоомж, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээнд нийцүүлэн

	Бизнесийн ёс зүйн дүрэм	Хувилбар:01
	Дугаар: MBW-BOD-05	Шинэчилсэн:

зохицуулах ёс зүйг баримтална. Хүний хөдөлмөрлөх болон хувийн амьдралын эрүүл тэнцлийг дэмжин тусална.

Бүх ажилтнууд өөрийн болон гэр бүлийнхээ үндсэн хэрэгцээг хангаж амьдрах хэмжээний цалин авах эрхтэй. Ажилтны цалин тогтоох, тооцож олгохдоо шударга ёсны зарчмыг баримтлан үнэн зөв тооцох, хүн ажилласан л бол хөдөлмөрийн хөлс олгох ёс зүйг баримтална.

- ГОМДОЛ ГАРГАХ ЭРХ

Хэн ч бай компанийн үйл ажиллагаа, зөрчигдсөн эрхийн тухай гомдол, санал гаргах эрхтэй байх зарчмыг баримтална. Ажилтныг гомдол санал гаргасны төлөө хариуцлага тооцохгүй, гомдол саналд зохих ёсоор хариу өгөх ёс зүйг баримтална.

Ажилтнууд болон сонирхогч этгээд нь цаг хугацаа, орон зайнаас хамаарахгүйгээр санал, гомдолоо info@mongolbasalt.mn цахим шуудангаар ирүүлэх боломжтой ба мэдээллийн нууцлалыг хадгална.

Гурав. ШУДАРГА БИЗНЕСИЙН ЁС ЗҮЙ

Компанийн эрх бүхий албан тушаалтан болон ажилтнууд ажил үүргээ гүйцэтгэх, компанийг төлөөлөхдөө шударга бизнесийн зарчмыг баримталж, дараах ёс зүйг баримтална. Үүнд:

- ӨРСӨЛДӨӨНИЙ ЁС ЗҮЙ

Компанийн эрх бүхий албан тушаалтан Өрсөлдөөний тухай хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаа явуулж, шийдвэр гаргаж бизнесийн орчинд шударга, ёс зүйтэй өрсөлдөж ажиллана.

Шударга өрсөлдөөнд харшлах аливаа гэрээ, хэлцэл байгуулахгүй байх, давамгайл байдлаа хууль бусаар ашиглахгүй байх, үнэ болон худалдааны бусад нөхцлийг өрсөлдөгч нартайгаа хэлэлцэж тохиролцохгүй байх ёс зүйг баримтална.

Ажилтнууд өрсөлдөгчид болон боломжит өрсөлдөгч нарт мэдээлэл дамжуулах, нууц мэдээллийг өгөх, харилцан солилцох, албан бус журмаар харилцаа үүсгэхгүй байх ёс зүйг баримтална.

- АВЛИГЫН ЭСРЭГ ЁС ЗҮЙ


Компанийн эрх бүхий албан тушаалтан, ажилтнууд ажил үүргээ гүйцэтгэх, бизнесийн харилцаа бий болгох, харилцаагаа хадгалах, шийдвэрт нөлөөлөх, бизнесийн үйл ажиллагаа явуулахад давуу талыг зохисгүйгээр олж авах зорилгоор бусдад үнэ цэнэ бүхий аливаа зүйл өгөхгүй, санал болгохгүй байх ёс зүйг баримтална.

Ямар нэгэн авлигыг хэн нэгнээс хаана ч, хэзээ ч асууж, өгөхөд оролцож, өгч, санал болгож, амлаж, давуу байдлыг баталгаажуулахгүй байх зарчмыг баримталж ажиллана.

Компанийн эрх бүхий албан тушаалтан, ажилтан нэг бүр ажил үүргээ чин үнэнч шударгаар гүйцэтгэн, шийдвэр гаргах явцад зүй бусаар нөлөөлөх, давуу байдал олгох зорилгоор аливаа гуравдагч этгээдээс хөнгөлөлт, урамшуулал, авлига, шан харамж авахгүй байх ёс зүйг чанд баримтлана.

- БЭЛЭГ, ХАНДИВЫН ЁС ЗҮЙ

Бизнесийн харилцаанд хамтрагч, түншүүд бие биедээ өгч буй бэлэг нь ямар нэгэн болзол агуулаагүй, хариу төлбөргүй ил тод байх зарчмыг баримтална.

	Бизнесийн ёс зүйн дүрэм	Хувилбар:01
	Дугаар: MBW-BOD-05	Шинэчилсэн:

Эрх бүхий албан тушаалтан, ажилтан хэн ч бай бусдаас бэлэг өгөхийг хүсэх, шаардахыг хориглоно. Компаниас бусдад өгсөн бэлэг, хандив нь хүлээн авагчид ямар нэгэн дарамт учруулахгүй байх зарчмыг баримтална.

Компанид болон эрх бүхий албан тушаалтнуудын хүлээн авч буй бэлэг нь бизнесийн үйл ажиллагаа, шийдвэр гаргах процесст нөлөөлөх, бусдад давуу байдал бий болгохыг хориглоно.

Компани Монгол улсын хууль тогтоомжийг зөрчин аль нэг улс төрийн нам, улс төрийн үйл ажиллагаанд нэр дэвшигч болон түүнтэй адилтгах хүнд хандив өгөхгүй байх ёс зүйг баримтална.

Компани нийгмийн хариуцлагын хүрээнд бизнесийн тогтвортой үйл ажиллагаа явуулахдаа аливаа хүмүүнлэгийн хандивт нэгдэх, буцалтгүй тусламж олгохыг хориглохгүй.

- МӨНГӨ УГААХТЭЙ ТЭМЦЭХ ЁС ЗҮЙ

Компани, эрх бүхий албан тушаалтнууд мөнгө угаах үйл ажиллагаанд оролцохгүй байх, эдийн засгийн хориг арга хэмжээтэй этгээдтэй бизнесийн харилцаанд оролцохоос зайлсхийх ёс зүйг баримтална.

Компанийн эрх бүхий албан тушаалтан, ажилтнууд бизнесийг гуравдагч этгээдийн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон бусад гэмт хэргийн хэрэгсэл болгохоос ямагт сэргийлж ажиллах үүрэгтэй. Энэхүү үүргийг харилцагч, хамтран ажиллагч, ханган нийлүүлэгчид нэгэн адил хүлээх бөгөөд эрсдэл бүхий нөхцөл байдал илэрсэн тохиолдолд хамтын ажиллагааг дуусгавар болгох арга хэмжээ авна.

- АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧЛИЙН ЁС ЗҮЙ

Компанийн эрх бүхий албан тушаалтан, ажилтнууд бизнесийн болон хувийн ашиг сонирхлын хооронд ямар нэгэн ашиг сонирхлын зөрчилдөөн гарахаас зайлхийх зарчмыг баримтална.

Эрх бүхий албан тушаалтанууд аливаа шийдвэр гаргахдаа хувийн ашиг сонирхолд нийцүүлэх буй компанийн хууль ёсны эрх ашиг сонирхол, хэрэгцээ шаардлагад нийцүүлэх ёс зүйг баримтална.

Компанийн ажилтнуудын хувийн ашиг сонирхол нь компанийн хууль ёсны ашиг сонирхолтой зөрчилдөхгүй байхад анхаарч, урьдчилан сэргийлж ажилладаг.

Ажилтнууд болон хамтрагч, ханган нийлүүлэгч бүр ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлж, ашиг сонирхлын зөрчил үүссэн эсвэл үүсч болохуйц нөхцөл байдлыг ил тод мэдээлэх үүрэгтэй байна.


- НИЙЛҮҮЛЭГЧИЙН ЁС ЗҮЙ

Компани бизнесийн хариуцлагатай, өндөр ёс зүйтэй харилцагч, хамтран ажиллагч, ханган нийлүүлэгчтэй харилцахыг зарчим болгоно.

Нийлүүлэгчээ бизнесийн үйл ажиллагаагаа хариуцлагатай явуулах үүргээ биелүүлэхийг уриалж хамтран ажиллах ба эерэгээр нөлөөлж, тогтвортой хариуцлагатай байдлаар хамтдаа өсөн дэвшихийг эрмэлзэж ажиллана.

Манай компанийн нийлүүлэгчид шударгаар өрсөлдөх, авлига, ашиг сонирхлын зөрчилөөс ангид байх, мөнгө угаах ямар нэгэн үйл ажиллагаанд оролцохгүй байх ёс зүйг баримтлах үүрэгтэй.

Нийлүүлэгчээс хүний эрхэм чанар болон хүний эрхийг хүндэтгэж бизнесийн үйл ажиллагаа эрхлэх, эрүүл аюулгүй ажлын байраар хангах, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөг багасгах үүрэгтэйг шаардаж ажиллана.

	Бизнесийн ёс зүйн дүрэм	Хувилбар:01
	Дугаар: MBW-BOD-05	Шинэчилсэн:

Дөрөв. ХӨРӨНГӨ ХАМГААЛАХ ЁС ЗҮЙН ДҮРЭМ

Компанийн эрх бүхий албан тушаалтан болон ажилтнууд ажил үүргээ гүйцэтгэх, компанийг төлөөлөхдөө компанийн эдийн болон эдийн бус аливаа хөрөнгийг үр ашиггүй зарцуулах, хувьдаа ашиглахыг үйлдэл эс үйлдэхүйг үл тэвчих ёс зүйг баримтална. Үүнд:

- КОМПАНИЙН ХӨРӨНГӨ АШИГЛАХ ЁС ЗҮЙ

Ажилтан нэг бүр компанийхаа биет болон биет бус хөрөнгүүдийг анхаарал болгоомжтой, мэргэжлийн байдлаар ашиглаж, хамгаалах үүрэгтэй. Компанийн хөрөнгийг зөвхөн бизнесийн үйл ажиллагааны зорилгоор албан хэрэгцээнд ашиглах ёс зүйг баримтална.

Хүн нэг бүр компанийн хөрөнгийг зөвшөөрснөөс бусад хувийн хэрэгцээнд ашиглаж болохгүй бөгөөд компанийн хөрөнгийг хулгайлах, залилан мэхлэх, хувьдаа шамшигдуулах зорилгоор мэдээ тайланг буруу гаргах зэрэг аливаа зүй бус үйлдлүүд хийх байх ёс зүйг баримталж ажиллана.

- ЗАЛИЛАНГИЙН ЭСРЭГ ЁС ЗҮЙ

Компани өөртөө болон бусдад үнэ цэнэтэй зүйл /мөнгөн хөрөнгө, өмч, мэдээлэл гэх. мэт/ эсвэл давуу тал олж авах зорилгоор хууран мэхлэх, хохирол учруулах үйл ажиллагааг дэмждэггүй бөгөөд компани аливаа төрлийн залиланг хүлээн зөвшөөрөхгүй.

Эрх бүхий албан тушаалтан, ажилтнууд аливаа залилан мэхлэх үйлдэл гаргахгүй байх, залилан мэхлэх үйлдлийн эсрэг хариу арга хэмжээ авдаг байх, шалтгаан нөхцлийг арилгаж чаддаг байх ёс зүйг баримтална.

- МЭДЭЭЛЛИЙН НУУЦ ХАМГААЛАХ ЁС ЗҮЙ

Компани бизнесийн үйл ажиллагаандаа ажилчид, хэрэглэгчид, нийлүүлэгчид болон бусад бизнесийн хамтрагчдынхаа хувийн мэдээлэл аюулгүй байдлыг бүрэн хамгаалах зарчмыг баримтлана.

Эрх бүхий албан тушаалтан, ажилтнууд компанийн болон хувь хүний үнэ цэнэтэй мэдээллийг хүндэтгэж, хамгаалах ёс зүйг чанд баримтална.


Компани бизнесийн нууц мэдээллийг хууль, журмын дагуу хамгаалж, ажилтнууд ажил хэргийн зорилгоор зөвшөөрөлтэй ашиглах, нууц мэдээллийг задруулахаас урьдчилан сэргийлэх, хамгаалах бүх талын арга хэмжээг авч, хариуцах үүрэгтэй.

Компани хувь хүний мэдээллийг хөдөлмөрийн эрхлэлтийн харилцааны зорилгоор холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын дагуу авч боловсруулж, хадгалж, ашиглах ба бусад зорилгоор ашиглахгүй, дамжуулахгүй байх ёс зүйг баримтална.

- ОЮУНЫ ӨМЧИЙГ ХАМГААЛАХ ЁС ЗҮЙ

Компанийн эрх бүхий албан тушаалтан, ажилтнууд Оюуны өмчийг хүндэлж, хамгаалах, бусдын оюуны өмчийн эрхэд халдахгүй байх, компанийн Оюуны өмчийн эрхийг зөрчихгүй байх ёс зүйг баримтлан ажиллана.

Оюуны бүтээлч үйл ажиллагааны үр дүнд бий болсон оюуны өмчийн эрхийг хүндэтгэн хамгаалж, хууль тогтоомжийн дагуу баталгаажуулж ашиглах ба бусдын оюуны өмчийн эрхийг зөрчихгүй байхыг эрхэмлэнэ.

	Бизнесийн ёс зүйн дүрэм	Хувилбар:01
	Дугаар: MBW-BOD-05	Шинэчилсэн:


- ОЛОН НИЙТИЙН СҮЛЖЭЭ АШИГЛАЛТЫН ЁС ЗҮЙ

Компанийн эрх бүхий албан тушаалтан, ажилтнууд болон нийлүүлэгчид хувийн болон компанийн нэрийн өмнөөс олон нийтийн сүлжээг ашиглахдаа ил тод байж, үнэн зөв, бусдад хүндэтгэлтэй хандах замаар зөв зохистой, соёлтой харилцааг бий болгох зарчмыг баримтлана.

Олон нийтийн сүлжээнд компанийн болон хувь хүний нууцад хамаарах мэдээллийг байршуулах, бусдыг ямар нэгэн төөрөгдөлд оруулахуйц худал мэдээлэл түгээхийг хориглоно.

Компанийн үйл ажиллагаанд мэдээлэл солилцох зорилгоор ашиглаж буй олон нийтийн сүлжээ, группэд албан харилцааны бус мэдээлэл оруулах, бусдын нэр хүндэд халдах, доромжлох, дарамтлах аливаа үйлдэл гаргахгүй байх, дотоод мэдээллийн нууцлалыг чандлан хадгалах ёс зүйг ажилтан бүр чанд баримтлана.

ooOoo

	Бизнесийн ёс зүйн дүрэм	Хувилбар:01
	Дугаар: MBW-BOD-05	Шинэчилсэн:

Тав. ШҮГЭЛ ҮЛЭЭХ

ТАНЫ ҮҮРЭГ

Компани ажилтнуудын болон оролцогч талуудын ШҮГЭЛ ҮЛЭЭСЭН мэдээллийг хүлээн авч, зохих журмын дагуу шалган шийдвэрлэх зарчмыг баримтлана.

Компанийн ажилтнууд аливаа зүй бус үйлдэл эсхүл хууль тогтоомж болон Бизнесийн ёс зүйн дүрмийг зөрчсөн үйлдлийн талаар мэдээлэх үүрэгтэй байна. Шүгэл үлээх нь зүй ёсны үйлдэл бөгөөд шүгэл үлээсэн ажилтан, бусад этгээдийг шүгэл үлээснийх нь төлөө ямар нэгэн хариуцлага хүлээлгэхгүй байх ёс зүйг баримтлана.

МЭДЭЭЛЭЛ ХҮЛЭЭН АВАХ

Зөрчлийн талаарх мэдээллийг дараах сувгуудаар дамжуулан амаар болон бичгээр хүлээн авна. Үүнд:

- Шууд удирдлага, Захиргаа хүний нөөцийн менежер, дотоод хяналтын ажилтнуудаар дамжуулан өгөх
- info@mongolbasalt.mn цахим шуудангаар илгээх
- ТУЗ-өөс томилогдсон Комплайнсын ажилтанд хандаж өгөх

ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ

Компани мэдээлэл хүлээн авах сувгуудаас ирсэн сэжигтэй болон зохисгүй үйл ажиллагааны талаарх мэдээллүүдийг Комплайнсын ажилтанд нэгтгэн бүртгүүлж, нягтлан шалгах, шийдвэрлэх, шүгэл үлээгчид хариу өгөх арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Шүгэл үлээгч нь хариуг эс зөвшөөрсөн гомдол гаргах эсхүл ТУЗ-ийн шийдвэрээр дотоод аудитын нэгжтэй хамтран хяналт шалгалтын удирдамж батлан холбогдох шалгалтыг хийж тайлагнана.

Комплайнсын ажилтан Шүгэл үлээсэн мэдээллийн бүртгэл, шалгасан болон хариу өгсөн тухай тайланг улирал бүр ТУЗ-ийн хуралд танилцуулж ажиллана.

САХИЛГЫН БОЛОН ХУУЛИЙН ХАРИУЦЛАГА

Компанийн эрх бүхий албан тушаалтан, ажилтнууд хууль тогтоомж, бодлого, энэхүү дүрэм, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээг зөрчсөн эсхүл дотоод хяналт шалгалтаар үйл ажиллагаанд нийцүүлж ажиллаагүй болох нь тогтоогдсон бол сахилгын болон хуулийн хариуцлага хүлээх үндэслэл болно.

Компани сахилгын шийтгэл ногдуулахдаа зөрчил гаргасан нөхцөл байдал, хугацаа давтамж болон зөрчлийн хор хохирол зэрэг нөхцөл байдлуудыг харгалзан үзэж Хөдөлмөрийн тухай хуульд заасан журмыг баримтална. Харин эрх бүхий албан тушаалтны болон ажилтны гаргасан зөрчил нь гэмт хэргийн шинжтэй байвал хууль хяналтын байгууллагаар шалгуулахаар шилжүүлнэ.

ooOoo